**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# “Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа”-нд хийсэн нийцлийн аудитын тайлан

/ДУА-2018-01-НА/




***Сонгон шалгаруулалтгүйгээр удирдах болон төрийн албаны жинхэнэ албан хаагчийг томилсон зөрчил байсаар байна.***

2018 он

## АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа

Аудитын менежер Х.Наранцацрал

Ахлах аудитор Д.Ихбаяр

Аудитор Д.Должинсүрэн

**Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утсаар харилцана уу.**

Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү.

**www.audit.mn**

Хаяг:
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар

**2018 оны 6 дугаар сар**


| | |
|---|---|
| Товчилсон үгс | 3 |
| График болон хүснэгтэн мэдээллийн жагсаалт | 4 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, үндсэн мэдээлэл | 5-7 |
| **Бүлэг 1. Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдаж байна.** | |
| 1.1 ТАЗ нь ТАСЗ -ийг арга зүйн удирдлагаар хангаж байгаа боловч орон нутгийн ТАСЗ -ийн хараат бус байдал бүрэн хангагдахгүй байна. | 8-12 |
| 1.2 Төрийн албаны Дундговь дахь салбар зөвлөл 2017 онд тавьсан зорилтоо 96.4 хувьтай биелүүлсэн байна. | 12-13 |
| **Бүлэг 2. Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт журмын дагуу зохион байгуулагдсан байна.** | |
| 2.1 Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт зөвхөн төрийн байгууллагуудаас ирүүлсэн захиалгаар хязгаарлагдаж байна. | 13-16 |
| 2.2 Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа, шалгалттай холбоотой өргөдөл, гомдлыг журмын дагуу бүрэн шийдвэрлэсэн байна. | 16-18 |
| 2.3 Төрийн албаны Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын хураамжийн орлого, түүний зарцуулалтыг аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайланд тайлагнаагүй байна. | 18-19 |
| **Бүлэг 3. Төсвийн байгууллагууд хүний нөөцийн бодлого, стратеги төлөвлөгөөгүй ажиллаж байна.** | |
| 3.1 Төрийн байгууллагууд хүний нөөцийн бодлого страгеги төлөвлөгөөгүй ажиллаж, удирдах болон төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулалтгүйгээр томилжээ. | 19-23 |
| 3.2 Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний 2017 оны нэгдсэн дүн гараагүй байна. | 24 |
| Дүгнэлт | 25 |
| Зөвлөмж | 26 |
| Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар | 27 |
| Тайлан баталгаажуулах тушаал | 28-34 |
| Тайлангийн хавсралтууд | 35-38 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **УИХ** | Улсын Их Хурал |
| **ИТХ** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| **АДБОУС** | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| **ҮАГ** | Үндэсний аудитын газар |
| **ЗДТГ** | Засаг даргын Тамгын газар |
| **ТАЗ** | Төрийн албаны зөвлөл |
| **ТАСЗ** | Төрийн албаны салбар зөвлөл |
| **ТАХ** | Төрийн албан хаагч |
| **ХШҮ** | Хяналт-шинжилгээ, үнэлгээ |
| **ХОХБТ** | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт |
| **ТАМШ** | Төрийн албаны мэргэшлийн шалгалт |
| **ХХҮГ** | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар |
| **ИГЧБЦГХЗ** | Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа |
| **УАСШ** | Удирдах ажилтны сонгон шалгаруулалт |
| **НДХ** | Нийгмийн даатгалын хэлтэс |
| **ЗГ** | Засгийн газар |
| **ГХБХБГ** | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |
| **БХБ** | Барилга, хот байгуулалт |
| **ТЗ** | Төрийн захиргаа |
| **ТҮ** | Төрийн үйлчилгээ |
| **ТТ** | Төрийн тусгай |
| **УТ** | Улс төрийн |
| **ТХ** | Тэмдэгтийн хураамж |
| **ЭБАТ** | Эрх бүхий албан тушаалтан |
| | |

## ГРАФИК БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ


| | |
|---|---|
| **Хүснэгт 1** | Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үнэлгээ /Сүүлийн 3 жилээр/ |
| **Хүснэгт 2** | Хүчингүй болсон хуулийн заалт үндэслэсэн дүрэм, журмууд |
| **Хүснэгт 3** | ТАХ-ийн сонгон шалгаруулалтын тоон мэдээлэл |
| **Хүснэгт 4** | Нэг удаа захиалга өгөөд нөхөгдөөгүй боловч ахиж, зарлагдаагүй ажлын байрны судалгаа |
| **Хүснэгт 5** | ТАХ-ийн шалгалтад тэнцээгүй иргэдийн судалгаа |
| **Хүснэгт 6** | Төрийн удирдах албан хаагчийн шалгалтад тэнцээгүй иргэдийн судалгаа |
| **Хүснэгт 7** | ТАХ-ийн шалгалт өгсөн иргэдийн судалдаа |
| **Хүснэгт 8** | ТАХ-ийн шалгалт өгөөгүй иргэдийн судалгаа |
| **Хүснэгт 9** | ТАХ-ийн шалгалт өгөөд томилогдоогүй иргэдийн судалгаа |
| **Хүснэгт 10** | ТАХ-ийн шалгалт өгөөгүй удирдах албан тушаалтан |
| **График 1** | ТАСЗ-д ирсэн өргөдөл, гомдол, маргааны шийдвэрлэлт |
| **График 2** | ТАХ-ийн шалгалт өгөөд томилогдоогүй иргэдийн судалгаа |
| **График 3** | Дундговь аймгийн төрийн албан хаагчдын тоо |

**АУДИТЫН НЭР:** ***"ТӨРИЙН АЛБАНЫ ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА"***
**АУДИТЫН КОД:** **ДУАГ/2018/НА-01**

## АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны "Аудитын сэдэв батлах тухай" 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/12 дугаар тушаалаар баталсан "Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөө", Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын захиалгаар Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ

Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулгахад аудитын зорилт чиглэгдлээ.

## ДЭД ЗОРИЛТ

- Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх;
- Төрийн албаны мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт хуулийн хүрээнд явагдаж буй эсэх;
- Төрийн албан хаагчийн тоо, хүний нөөцийн асуудал оновчтой байгаа эсэх.

## АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2015, 2016, 2017 оны үйл ажиллагааны баримт материал, хурлын тэмдэглэл, тогтоол, шийдвэрүүд, нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалга, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

## АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлав.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Аудитын Олон Улсын стандарт;
- Төрийн аудитын тухай хууль;
- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Төсвийн тухай хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Дүрэм батлах тухай тухай УИХ-ын 87 дугаар тогтоол;
- Журам батлах тухай МУЗГ-ын 62 дугаар тогтоол;
- Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 8 дугаар тогтоол;
- Заавар батлах тухай ТАЗ-ийн 14 дүгээр тогтоол;
- Журам батлах тухай ТАЗ-ийн 99 дүгээр тогтоол;
- Журам батлах тухай ТАЗ-ийн 128 дугаар тогтоол;
- Журам батлах тухай ТАЗ-ийн 63 дугаар тогтоол;
- Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн тогтоол, шийдвэрүүдийг шалгуур болгон ашиглав.

## АУДИТЫН ХУГАЦАА, БАГИЙН БҮРЭЛДХҮҮН

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2018 оны 03 дугаар сарын 15 –ны өдрөөс эхлэн 6 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар хийж гүйцэтгэлээ.

## АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх, хоёрдугаар бүлэгт төрийн албаны мэргэжлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж байгаа эсэх, гуравдугаар бүлэгт төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилт оновчтой байгаа эсэх талаар тусгаж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

## АУДИТЫН ЯВЦАД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

2018 оны эхэнд нийцлийн аудитын алба 1 орон тоо дутуу ажилласан бөгөөд аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдэх нийцлийн аудитууд хугацаандаа эхлээгүйгээс шалтгаалж, аудитын хөтөлбөрийн хугацаа алдагдахад хүрсэн.

## АУДИТЫН ДҮН

Аудитаар нийт 181,359.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 1,060.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 181,299.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн салбар зөвлөл 2017 онд стратегийн 5 үндсэн зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Арга хэмжээний хүрээнд 38 ажил, үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур, тоо, чанар, хугацаагаар тодорхойлон төлөвлөж, Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, улирал тутам үр дүнг тооцож ажилласан байна.

*Удирдах ажилтны сонгон шалгаруулалт:* Төсвийн байгууллагуудын санал, захиалгыг үндэслэн 2017 онд төрийн жинхэнэ албаны 14, төрийн үйлчилгээний албаны 22 удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 8 удаа зохион байгуулсан.

Энэхүү 8 удаагийн сонгон шалгаруулалтаар 26 ажлын байранд 70 иргэн бүртгүүлж хамрагдсанаас 32 иргэн тэнцэж, 21 иргэнийг нэр дэвшүүлсэн. 4 иргэнийг ТАСЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гарган, сум, байгууллагын төрийн албаны удирдах албан тушаалд нэр дэвшүүлж, томилуулсан.

*Мэргэшлийн шалгалт*: Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалгыг үндэслэн төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2017 онд 3 удаа зохих журам, удирдамжийн дагуу зохион байгуулсан байна.

Энэхүү 3 удаагийн мэргэшлийн шалгалтаар 52 ажлын байр зарлагдсанаас 36 ажлын байранд 244 хүн бүртгүүлж, эдгээрээс 61 хүн шалгалтандаа тэнцэж, өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авсан 22 иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тухайн ажлын байранд нэр дэвшүүлсэн байна.

ТАСЗ-ийн үйл ажиллагаанд өгсөн сүүлийн 3 жилийн үнэлгээг харуулбал:

Хүснэгт №1

**Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үнэлгээ** ***/Сүүлийн 3 жилээр/***

| Он | Авбал зохих оноо | Авсан оноо | Үнэлгээ хувь | Эзэлсэн байр |
|---|---|---|---|---|
| **2015** | 210 | 158 | 75.2 | 13 |
| **2016** | 250 | 181 | 72.4 | 8 |
| **2017** | 205 | 162 | 79.0 | 6 |

Хүснэгтээс харахад сүүлийн 3 жилд авсан нийт оноо 2016 онд өмнөх оноос 2.8 оноогоор буурсан, 2017 онд 6.6 оноогоор өссөн байна. Улсын хэмжээнд аймгуудийн салбар зөвлөлүүдийн хүрээнд ажлаараа 2014, 2015 онд 12-13 дугаар байр эзэлж байсан бол 2016, 2017 онд 8-6 дугаар байр эзэлжээ.

## *БҮЛЭГ 1.* Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдаж байна.

### 1.1. ТАЗ нь ТАСЗ-ийг арга зүйн удирдлагаар хангаж байгаа боловч орон нутгийн ТАСЗ-ийн хараат бус байдал бүрэн хангагдахгүй байна.

“Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичиг”- ийг Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор баталсан нь төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх, түүний тэргүүлэх чиглэлийг тогтооход чухал ач холбогдолтой болжээ.

Уг баримт бичигт төрийн албаны шинэтгэлийн эрхэм зорилго, эрхэмлэн дээдлэх зүйлс, төрийн албаны шинэтгэлийн зарчим, бодлого, стратегийг тодорхойлсон байна. Тухайлбал: Төрийн албаны эрхэм зорилго нь “*Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачлагатай манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх*”- д оршино гэжээ.

Энэхүү эрхэм зорилгод чиглэсэн эрхэмлэх үнэт зүйлс, шинэтгэлийн зарчим, бодлогод тулгуурласан харилцан уялдаа холбоо бүхий доорх 6 стратегийг тодорхойлж эдгээрийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын стратеги
2. Манлайлал болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтын стратеги
3. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийн стратеги
4. Бодлогын шинжилгээ болон тоо баримтын стратеги
5. Төрийн албаны оновчтой хэмжээний стратеги
6. Цалин хөлс болон хангамжийн стратеги

Дээрх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗГ-ын 2007 оны 128 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

ТАСЗ нь ТАЗ-ийн 213 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.1[1]. дэх заалтын дагуу төрийн албаны шинэчлэлийн хүрээнд дээрх стратегийн зорилтуудад суурилан жил, улирлын ажлын төлөвлөгөөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцон ажлаа ТАЗ-д тайлагнаж байна.

ТАСЗ нь төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэстэй хамтран жил бүр хийсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан ”Бодлогын баримт

[1] тухайн салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн албаны шинэтгэл, төрийн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулахад мэргэшлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх;

бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3.2.3.8[2]-д заасны дагуу 2017 оноос эхлэн хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг шалгах асуудлын нэг үзүүлэлт болгон дүгнэсэн байна.

УИХ-ын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.7.4.[3]-т заасны дагуу ТАЗ нь ТАСЗ -үүдийн үйл ажиллагааны тайланг, урьдчилан баталсан журам, аргачлал болон тухай жилийн туршид зөвлөлд ирүүлж байсан тайлан мэдээ, бусад мэдээллийн эх үүсвэрийг үндэслэн үнэлж, дүгнэлт зөвлөмж өгсөн байна.

2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын хүрээнд ТАЗ-өөс өгсөн зөвлөмжийг 96.0 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Харин 2017 онд ТАЗ-өөс "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ыг зөрчсөн томилгоо нэлээд байгааг дурдаж зөрчлийг 2018 оны 01 дүгээр сард багтаан арилгаж хариу ирүүлэх зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн дагуу сум, агентлагийн дарга нарт зөрчлийг арилгах талаар чиглэл өгч, 9 байгууллагын 12 албан тушаалын томилгооны зөрчлийг арилгасан талаар ТАЗ-д хариу хүргүүлсэн боловч аудитаар томилготой холбоотой зөрчил илэрсэн. */Тайлангийн 2,3-р бүлэг/*

ТАЗ нь холбогдох хууль тогтоомж, журамд заасан эрх, үүргийнхээ дагуу орон нутгийн ТАСЗ-ийг Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрийн албаны шинэтгэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Хэдий тийм боловч ТАЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой одоо мөрдөгдөж байгаа дүрэм, журам, тогтоолд хүчингүй болсон буюу Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийг үндэслэсэн заалтууд байсаар байна. /Хүснэгт № 2/

Тиймээс төрийн албаны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дараах дүрэм, журам, тогтоолд тус тус өөрчлөлт оруулах талаар ТАСЗ-д санал хүргүүлэх нь зүйтэй байна.

Хүснэгт №2 Хүчингүй болсон хуулийн заалт үндэслэсэн дүрэм, журмууд

| **№** | **Дүрэм, журам, зааврын нэр** | **Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн заалт** |
|---|---|---|
| **1** | Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм | 44 дүгээр зүйл |
| **2** | Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам | 45.1.1-45.1.7 |
| **3** | Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам | 47.3 |

[2] хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

[3] ñàëáàð çº âëº ë í ü Çº âëº ëèéí º ì í º àæëàà ø óóä õàðèóöàõ áº ãº ä Çº âëº ë ñàëáàð çº âëº ëèéí æèëèéí àæëûí òàéëàí ãàäàðàà î í û 1 ä¿ãýýð ñàðä áàãòààí àâ÷, õóðàëäààí ààðàà õýëýëöýí ¿í ýëãýý ä¿ãí ýëòº ã÷, öààø èä àâàõ àðãà õýì æýýí èé òàëààð ø èéäâýð ãàðãàí ò¿¿í èéã õýðýãæ¿¿ëýõ àæëûí ãçî õèî í áàéãóóëàõ;

эзрх зөрчилд 2014 онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар зөвлөмж өгөгдсөн боловч журамд өөрчлөлт оруулаагүй байна.

ТАСЗ нь ТАЗ-өөс шаардсан болон цаг үеийн графикт тайлан, мэдээг хугацаанд нь гарган хүргүүлж хэвшсэн байна.

Мөн ТАЗ-өөс шинэчлэн гаргасан тогтоол, шийдвэр, журмыг төрийн байгууллагуудад сурталчлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн төвийн болон сумдын төрийн байгууллагуудад гарын авлага бэлтгэн тараасан байна.

Аудитаар ТАЗ-өөс сүүлийн үед авч байгаа шинэлэг арга хэмжээний үр дүнд салбар зөвлөлийн хэмжээнд тулгарах бэрхшээл, шийдвэрлэх асуудал харьцангуй бага болсон мэт байгаа боловч дараах асуудлууд дээр анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Эрх бүхий албан тушаалтан төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг томилохдоо холбогдох хууль тогтоомжийг баримтлан, нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах зарчмыг үл ойшоож, "үүрэг гүйцэтгэгч" хэмээх ямар ч хуульд байхгүй нэр томъёогоор шууд томилох, тухайн сул орон тоо буюу ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг "тодорхой хүнд" зориулан өөрчилж батлах, төрийн захиргааны албан тушаалын ажлын байранд "гэрээт" нэрээр авч ажиллуулж, улмаар төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад оруулан "нөөцөд" бүртгэж, тангараг өргүүлэх зэрэг зөрчлүүд сүүлийн жилүүдэд түлхүү ажиглагдаж байна.



**ТАСЗ хараат бус ажиллаж чадахгүй байна.**

Энэ нь ТАЗ-өөс түүнд хяналт тавьж арга хэмжээ авч, зөрчлийг таслан зогсоох эрх мэдэл дутмагаас зөвлөлийн хараат бус байдал алдагдах нэг нөхцөл бүрдэж, ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.6[4] дахь заалт хэрэгжихгүй байна гэж үзэж байна.

ТАЗ нь төрийн албанд улс төрийн нөлөө оруулахгүй, төрийн албан хаагчийн зүгээс улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх баталгааг хангаж, хяналт тавин тодорхой зөрчлийг тухай бүр нь шалгаж, газар дээр нь арга хэмжээ авч ажиллахгүй байна.

Харин орон нутгийн ТАСЗ-ийн хувьд бүтэц зохион байгуулалт, хүн хүч, чиг үүргийн хувьд дээрх хяналтыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байсаар байна.

ТАСЗ-ийн ажиллах чиг үүрэг нь тодорхой, үүрэг хариуцлага өндөр, ачаалал их атал дарга, нарийн бичиг нь орон тооны бус, төсөв санхүү, хэрэгжүүлэгч болон удирдлагын хувьд аймгийн ЗДТГ-т хараат байдлаар ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл аймгийн ЗДТГ-ын дарга Салбар зөвлөлийн даргын, аймгийн ЗДТГ-ын хүний нөөц хариуцсан мэргэжилтэн нарийн бичгийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь төрийн албаны Салбар зөвлөлийн ажил, шинэтгэлийн бодлого орон нутагт үр дүн муутай хэрэгжиж, ажил цалгардах нөхцөл үүсэх эрсдэлтэй байна.

2008 онд Төрийн албаны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ТАСЗ-ийн чиг үүрэг үлэмж нэмэгдсэн боловч одоо болтол салбар зөвлөлийн нарийн

[4] Салбар зөвлөл нь орон тооны, орон тооны бус эсэхээс үл хамааран өөрийн үйл ажиллагааг аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даасан байдлаар явуулна.

бичгийн даргын албан тушаалыг орон тооны болгож батлаагүй хэвээрээ байгаа нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж, үр дүнтэй ажиллахад таагүй нөлөөлж байна.

Иймд ажил төрлийн хамрах цар хүрээ өргөжиж байгаагаас ТАСЗ-ийн нарийн бичгийн даргад ногдох ажлын ачаалал жил ирэх тусам ихсэж байгаа тул нарийн бичгийн даргын албан тушаалыг орон тооны болгож бие даасан байдлаар ажиллуулах, төрийн албаны салбар зөвлөлийн хууль тогтоомжоор олгогдсон хараат бус, бие даасан байдлыг хангаж, төрийн албаны шинэтгэлийн бодлогыг орон нутагт бүрэн хэрэгжүүлэх нөхцөл боломж, эрх мэдлийг нь нэмэгдүүлж өгөх талаар ТАЗ-д хандах нь зүйтэй байна.

### 1.2. Төрийн албаны Дундговь дахь салбар зөвлөл 2017 онд тавьсан зорилтоо 96.4 хувьтай биелүүлсэн байна.

ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолын дагуу тус аймаг дахь салбар зөвлөл 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулагдаж, журмын дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

ТАЗ-ийн 2015 оны 91 дүгээр албан тоотоор ирүүлсэн загварын дагуу аймгийн ТАСЗ-ийн 2017 оны төлөвлөгөөг стратегийн 5 үндсэн зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэх 38 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур тоо чанар, хугацаагаар тодорхойлон боловсруулж, төлөвлөгөөг 96.4 хувьтай биелүүлжээ.

Тус ТАСЗ төрийн албаны хууль тогтоомж, стандартуудын хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, төрийн албан хаагчдын чадавх, ажлын бүтээмж, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд ахиц дэвшил гаргах зорилт дэвшүүлэн тодорхой ажлууд зохион байгуулж ажилласнаар дэвшүүлсэн зорилтоо бүрэн хангаж ажилласан байна.

ТАСЗ аймаг, сумын төрийн захиргааны албан хаагч бүхий ёс зүйн хорооны үйл ажиллагаатай холбоотой ажил үүргийг ТАЗ-ийн 2010 оны 192 дугээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”ын 4.2[5]-дахь заалтын дагуу хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд 23 байгууллагад 3-7 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн хороо ажиллаж байгаа бөгөөд 2017 онд Цагаандэлгэр, Гурвансайхан сумын 2 байгууллагын ёс зүйн хорооноос 2 албан тушаалтантай холбоотой ирсэн дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэн, ТАЗ-д журмын дагуу тайлагнажээ.



**ТАСЗ 2018 оны байдлаар 9 удаа хуралдаж 28 тогтоол гаргасан.**

Мөн төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, байгууллагуудын ёс зүйн хороодыг арга зүйгээр хангаж, жил, улирлын төлөвлөгөөтэй ажиллуулан, хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна.

ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төрийн албаны салбар зөвлөлийн нийтлэг үүрэг буюу 2.1.6-д /Төсвийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон төрийн албан хаагчийн

[5] Төрийн албаны зөвлөл болон түүний салбар зөвлөл нь Ёс зүйн хорооны дүгнэлтийг тус тусын хуралдаанаар хэлэлцэнэ.

ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах/ гэж заасан байна.

Аймгийн хэмжээнд төрийн албаны шинэчлэл, төрийн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2010-2016 онд “Төрийн албан хаагчийн чадавхийг дээшлүүлэх хөтөлбөр”, “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-үүдийг батлан хэрэгжүүлсэн байна.

Харин Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6[6], 33.6.1[7], 33.6.2[8] дахь заалтын дагуу нийт сум, хэлтэс, агентлагууд байгууллагынхаа төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөгөөр тухайн жилдээ 3-6 зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

2018 оны байдлаар аймгийн хэмжээнд 17 дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд төрийн албаны шинэчлэл, боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Иймд 2016 онд хэрэгжиж дууссан хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн, дүн шинжилгээ хийж цаашид хэрэгцээ шаардлагатай байгаа хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2017 онд Салбар зөвлөл 16 удаа хуралдаж цаг үеийн тулгамдсан 71 асуудал хэлэлцэн шийдвэрлэж 66 тогтоол гаргасан байна.

Харин 2018 оны 5 сарын байдлаар ТАСЗ 9 удаа хуралдаж 28 тогтоол гарсан бөгөөд 59 албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгох тогтоол гаргасан нь УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 4[9], 5[10] дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд зөрчлийг давтан гаргуулахгүй байх талаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Мөн 2016 оны ТАСЗ-ийн 15 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн даргын албан тушаалд төрийн жинхэнэ албан ажил эрхлээгүй, удирдах албаны сонгон шалгаруулалтад ороогүй хүнийг томилуулах дүгнэлт гаргасан байна. Энэ нь УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам” –ын 14/а[11], 14/б[12] заалтуудыг зөрчсөн тул уг тогтоолыг ТАСЗ-ийн 2017 оны 14 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон бөгөөд дээрх тогтоолыг гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцоогүй байна.

6 Төрийн байгууллага нь дараах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ:
7 төрийн албан хаагчийн сургалт;
8 төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

9 төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх
10 төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах;
11 Òº ðèéí àëáàí û òóõàé õóóëèéí 17.1-ä çààñí û ääãóó òóõàé áàéãóóëëàãàä àæèëëàæ áàéãàà áóþ ó òº ðèéí õî ëáî ãäî õ áóñàä áàéãóóëëàãàä àæèëëàæ áàéãàà òº ðèéí æèí õýí ý àëáàí õààã÷äààñ ¿éë àæèëëàãààí û ¿ð ä¿í , òº ðèéí æèí õýí ý àëáàí òóø ààëä áýëòãýãäñýí áàéäàë, ì ýðãýø èëèéí ò¿âø èí ãýýð í ü 2-î î ñ äî î ø ã¿é õ¿í èéã ñî í ãî í ø àëãàðóóëæ Òº ðèéí àëáàí û çº âëº ë áóþ ó Ñàëáàð çº âëº ëèéí ä¿ãí ýëòèéã¿í äýñëýí àëáàí òóø ààë äýâø ¿¿ëýõ çàì ààð óãî ðî í òî î ãí º õº æáî ëí î ;
12 ýí ý æóðì ûí 14-ийн “а”-ä çààñàí àëáàí õààã÷ààñ í º õº õ áî ëî ì æã¿é áî ë Òº ðèéí àëáàí û çº âëº ë áóþ ó Ñàëáàð çº âëº ëèéí óäèðäàõ àëáàí òóø ààëûí û í º º öèéí æàãñààëòàä á¿ðòãýãäñýí èðãýäýýñ òóõàé àëáàí òóø ààëä òàâèõ ø ààðäëàãûã õàðãàëçàí 2-î î ñ äî î ø ã¿é èðãýí èéã ñî í ãî í ø àëãàðóóëæ Òº ðèéí àëáàí û çº âëº ë áóþ ó Ñàëáàð çº âëº ëèéí ä¿ãí ýëòèéã¿í äýñëýí óãî ðî í òî î ã í º õº æáî ëí î ;

Энэ нь ТАСЗ-ийн хараат бус байдал алдагдан, зөвлөлийн гишүүд эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж хууль бус шийдвэр гарган, бусдад давуу эрх олгож байгаа нь зарим төрийн албан хаагчийг хохироох эрсдэлтэй байна.

## *БҮЛЭГ 2.* Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт журмын дагуу зохион байгуулагдсан байна.

### 2.1. Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт зөвхөн төрийн байгууллагуудаас ирүүлсэн захиалгаар хязгаарлагдаж байна.

Дундговь аймаг дахь ТАСЗ-ийн 2015-2017 онд зохион байгуулсан мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын судалгааг дараах хүснэгтээр харууллаа. Үүнд:

Хүснэгт 3 ТАХ-ийн сонгон шалгаруулалтын тоон мэдээлэл

| № | Төрийн албаны салбар зөвлөл | Сонгон шалгаруулалт зарлагдсан ажлын байр | | | | Шалгалт өгсөн хүний тоо | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт зарлагдсан ажлын байр | Үүнээс | | | | | | |
| | | | Дүгнэлтээр | Нөөцөөс | Сонгон шалгаруулалтаар | Тэнцсэн | Ажилд орсон | Татгалзсан | Нөөцөд бүртгэгдсэн |
| 1 | Дундговь ТАСЗ мэргэшлийн шалгалт 2015 он | 46 | | 14 | 17 | 67 | 17 | 3 | 47 |
| | Дундговь ТАСЗ удирдах ажилтан 2015 он | 26 | 8 | | 11 | 21 | 11 | 1 | 9 |
| | **2015 оны дүн** | **72** | **8** | **14** | **28** | **88** | **28** | **4** | **56** |
| 2 | Дундговь ТАСЗ мэргэшлийн шалгалт 2016 он | 39 | | 16 | 5 | 60 | 5 | 9 | 46 |
| | Дундговь ТАСЗ удирдах ажилтан 2016 он | 16 | 8 | | 2 | 4 | 2 | 1 | 2 |
| | **2016 оны дүн** | **55** | **8** | **16** | **7** | **64** | **7** | **9** | **48** |
| 3 | Дундговь ТАСЗ мэргэшлийн шалгалт 2017 он | 52 | | 19 | 22 | 61 | 22 | 4 | 34 |
| | Дундговь ТАСЗ удирдах ажилтан 2017 он | 26 | 4 | | 20 | 32 | 20 | 1 | 12 |
| | **2017 оны дүн** | **78** | **4** | **19** | **42** | **93** | **42** | **5** | **46** |
| | **Ерөнхий дүн** | **205** | **20** | **49** | **77** | **245** | **77** | **18** | **150** |

ТАСЗ нь 2015-2017 оны хооронд төрийн жинхэнэ албан хаагч болон удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг давхардсан тоогоор 205 ажлын байранд зарлаж, 9.7 хувь буюу 20 байгууллагын хэлтэс, албаны дарга нарыг дүгнэлтээр, 23.9



**Шалгалтыг онлайнаар ил тод мэдээлж байна.**

хувь буюу 49 албан хаагчийг нөөцөөс, 77 буюу 37.5 хувийг сонгон шалгаруулалтаар томилсон байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтыг 2015 онд 2 удаа, 2016 онд 2 удаа, 2017 оны 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 564 иргэн шалгалт өгснөөс 33.3 хувь буюу 188 иргэн сонгон шалгаруулалтад тэнцсэн байна. Сонгон шалгаруулалтад тэнцсэн нийт иргэдийн 67.5 хувь буюу 127 иргэн нөөцөд бүртгэгдэж, 23.4 хувь буюу 44 иргэн тухайн албан тушаалд томилогдон, 9.1 хувь буюу 17 иргэн татгалзсан шалтгаанаар хасагдсан байна. Үүний хамгийн өндөр оноо авсан 11 иргэн өөрсдийн хүсэлтээр тухайн ажлын байранд ажиллахгүй гэж татгалзсан байна. Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар болон дүнг хууль, журмын дагуу ил тод мэдээлсэн байна.

Хүснэгт №3 –оос харахад төрийн жинхэнэ албан хаагч болон удирдах албан тушаалтны нөөцийн бүрдүүлэлт журмын дагуу зөвхөн төсвийн байгууллагуудын захиалга өгөгдсөн орон тоогоор хязгаарлагдаж байгаа нь учир дутагдалтай байна.

Хүснэгт №4 Нэг удаа захиалга өгөөд нөхөгдөөгүй боловч ахиж, зарлагдаагүй ажлын байрны судалгаа

| № | Зарлагдсан ажлын байр | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Захиалга өгсөн байгууллагын нэр | Нэгжийн нэр | Ажлын байрны | | | | |
| | | | нэр | хариуцсан асуудал | Ангилал, зэрэглэл | орон тоо | |
| 1 | Эрүүл мэндийн газар | Эмнэлгийн тусламжийн хэлтэс | Мэргэжилтэн | Сувилахуй болон хөнгөвчлөх эмчилгээ | ТЗ-5 | 1 | Шалгалт 2016 онд зарлагдаад ахиж зарлагдаагүй |
| 2 | | | Мэргэжилтэн | Халдварт өвчний асуудал | ТЗ-5 | 1 | Шалгалт 2016 онд зарлагдаад ахиж зарлагдаагүй |
| 3 | Дэлгэрцогт | | ЭМТ эрхлэгч | | ТҮЭТ-7 | 1 | Шалгалт 2015 оны 11 сараас хойш ахиж зарлагдаагүй |
| 4 | Адаацаг | ЗДТГ | Мэргэжилтэн | Малын эрүүл мэнд,бэлчээр газар тариалан, хүнсний аюулгүй байдал | ТЗ-3 | 1 | Шалгалт 2016 оны 10 сард зарлагдаад ахиж зарлаагүй |

Иймд ТАСЗ нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмын 2.2.4-д /Төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдол бүхий шаардлагатай мэдээ, судалгаа, материал, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудаас гаргуулж авах/ заасны дагуу төсвийн байгууллагуудын батлагдсан орон тооны судалгаа авч, төрийн албаны шалгалт өгөөгүй албан хаагчид болон захиалга өгөөд албан хаагч томилогдоогүй ажлын байранд хяналт тавьж, сонгон шалгаруулалт зарлах бүрдээ нөхөгдөөгүй ажлын байруудад шалгаруулалт зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

2018 оны 5 сарын байдлаар дараах байгууллагууд төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцээгүй ажилтныг ажиллуулж байна. Үүнд:

Хүснэгт №5 ТАХ-ийн шалгалтад тэнцээгүй иргэдийн судалгаа

| № | Сум, байгууллагын нэр | Албан тушаалын нэр | Одоо ажиллаж àëáàí õààã÷èéí îâîãíýð | Òîìèëñîí òóøààë, îãíîî | Цалингийн шатлал | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ХХҮГ | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэн | Эрдэнэтогтох Одонтуяа | ХХҮГ-ын даргын 2016.11.03-ны Б/62 | ТҮ-6-1 | Шалгалтад тэнцээгүй |
| 2 | ХХҮГ | Өрхийн хөгжил хөтөлбөр хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн | Цэдэнбат Энхтуяа | ХХҮГ-ын даргын 2017.03.06-ны Б/12 | ТҮ-6-1 | Шалгалтад тэнцээгүй |
| 3 | ИГЧБЦГХЗ | Байгаль хамгаалагч | Төмөр-Ухна Болдбаатар | ХЗ-ны даргын 2015.09.22-ны Б/19 | ТҮ-1 | Шалгалтад тэнцээгүй |



УАСШ-д тэнцээгүй иргэдийг үүрэг гүйцэтгэгчээр томилж байна.

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 2015 онд 6 удаа, 2016 онд 3 удаа, 2017 онд 8 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 120 иргэн шалгалт өгснөөс 27.5 буюу 33 иргэн тэнцэж, ТАСЗ-ийн хуралдаанаар 20 иргэнийг дүгнэлт гаргаж шалгаруулсан байна. Сонгон шалгаруулалтаар тэнцсэн нийт иргэдийн 40.3 хувь буюу 23 иргэн нөөцөд бүртгэгдэж, 5.3 хувь буюу 3 иргэнийг төсвийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзсан байна.

2018 оны байдлаар төрийн албаны салбар зөвлөлөөс удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй, дүгнэлт гаргуулаагүй томилогдон ажиллаж байгаа удирдах ажилтны судалгааг нэгтгэн гаргасан боловч одоог хүртэл зөрчлийг арилгах талаар арга хэмжээ аваагүй, асуудал шийдэгдээгүй байна. Судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6 Төрийн удирдах албан хаагчийн шалгалтад тэнцээгүй иргэдийн судалгаа

| № | Сум, байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Томилсон тушаалын огноо, дугаар | Цалингийн шатлал | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гурвансайхан сумын Цэцэрлэг | Үүрэг гүйцэтгэгч | Д.Болормаа | Аймгийн ЗД-ын 2017.09.12-ны Б/35 | ТҮБД-4-5 | Шалгалтад тэнцээгүй |
| 2 | Луус сумын Цэцэрлэг | Үүрэг гүйцэтгэгч | С.Сугирсүрэн | 2017.12.04 Б/48 | ТҮБД-6-1 | Шалгалтад Тэнцээгүй |
| 3 | Сайхан-Овоо сумын Сургууль | Даргын үүрэг гүйцэтгэгч | О.Түмэнбаатар | 2017.03.13 №Б/09 | ТҮБД-7-2 | Шалгалт өгөөд тэнцээгүй |

Энэ нь Төрийн албаны салбар зөвлөлд журмын дагуу удирдах ажилтныг сонгон шалгаруулах захиалгыг ирүүлэхгүй байх, сонгон шалгаруулалт зохион

байгуулсан ч шаардлага хангасан нэр дэвшигч шалгарахгүй байх, сумдын хувьд хүний нөөц бүрдэхгүй байх шалтгаантай боловч төрийн байгууллагууд хүний нөөц бүрдүүлэх тал дээр санаачлагатай ажиллаж, салбар зөвлөлтэй хамтран, асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх шаардлагатай байна. Үүнээс гадна удирдах ажилтны хууль бус томилгоо хийгдэж, "Үүрэг гүйцэтгэгч" гэсэн хууль, журамд байхгүй нэршил одоо болтол хэрэглэгдсээр байна. /Хүснэгт № 10/

"Удирдах ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн хүн томилогдох хүртэлх хугацаанд ажилд түр томилох", "Гэрээгээр ажил гүйцэтгүүлэх", "Үүрэг гүйцэтгэгчийг томилох тухай" гэх мэт шийдвэрээр удирдах ажилтанг шууд томилж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 4.3.1-т /Дэд дарга, орлогчтой байгууллагын даргын албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд албан үүргийг нь дэд дарга, орлогчоор, тэд орлох боломжгүй бол чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар;/, тус журмын 4.3.2-т /Дэд дарга, орлогчгүй байгууллагын даргын албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар/, тус журмын 5.4-т /Эзгүй байгаа албан хаагчийн болон сул орон тоо гарсан албан тушаалын албан үүргийг энэ журамд зааснаас бусад этгээдээр түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно/ заасныг тус тус зөрчсөн байна.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30.1.10-т /Хууль тогтоомжид заасан бол нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллагын удирдлагыг аймаг, нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх/, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан " Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ын а-гаас в дэх заалтуудыг тус тус зөрчсөн юм.

Иймд удирдах ажилтны томилгоог хууль, журмын дагуу хийх талаар аймгийн Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

### 2.2. Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа, шалгалттай холбоотой өргөдөл, гомдлыг журмын дагуу бүрэн шийдвэрлэсэн байна.



**ТАСЗ ирсэн ихэнх маргаан ЭБАТ-ны гарсан шийдвэртэй холбоотой маргаан байна.**

Төрийн албан хаагчдаас 2015-2017 оны хооронд ирүүлсэн өргөдөл, гомдол, маргааны тоо жил ирэх тусам өссөн байна. Ирүүлсэн өргөдөл, гомдолд зохих журмын дагуу шийдвэрлэн хариу өгч ажилласан байна. Төрийн албан хаагчдаас ирүүлсэн өргөдлийн ихэнхи хувь нь ажилд томилуулах, нөөцөд бүртгүүлэх талаар байгаа нь төрийн байгууллагууд нэр дэвшүүлсэн албан хаагчийг томилохгүй татгалздаг, ТАСЗ сул байгаа орон тооны судалгаа гаргаж сонгон шалгаруулалт зохион байгуулдаггүйтэй холбоотой байна.

ТАСЗ нь УИХ-ын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-д заасны дагуу албан тушаалаас буруу

үндэслэлээр чөлөөлсөн болон ёс зүйн хэмжээг зөрчсөнтэй холбогдож гарсан маргааныг хянан шийдвэрлэсэн байна.

График №1




- 2016 онд ёс зүйн хэмжээг зөрчсөнтэй холбоотой 3 маргаан гарсан байна. Луус сумын иргэн Б.Алтанчимэгийн өгсөн өргөдлийн дагуу 2 ТАХ-тай холбоотой ёс зүйн зөрчлийг ТАСЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, ёс зүйн зөрчил гаргаагүй гэж шийдвэрлэсэн байна. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн удирдлагын шийдвэрээр байгууллагын дотоод журам болон ёс зүйн дүрэм зөрчсөн ТАХ-д Төрийн албаны тухай хуулийн 13.1.3, 13.1.5, Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн 5.1.2, 5.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн албаны тухай хуулийн 26.1.3-д заасан арга хэмжээ авсан байна.
- Албан тушаалаас буруу үндэслэлээр чөлөөлсөн маргаантай холбоотой нийт маргааны 22.2 хувь буюу 2 маргааныг /2017 оны/ эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэлгүй гэж ТАСЗ-өөс үзэж эргүүлэн ажилд томилуулж, 2 маргааныг шүүхээр шийдвэрлэхийг зөвлөж, 66.6 хувь буюу 6 маргааныг эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн байна.

ТАСЗ  2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.10-т заасны дагуу ёс зүйн зөрчлийн болон өргөдөл, гомдол, маргааны мэдээг хагас болон бүтэн жилээр гаргаж, мөн оны 7 дугаар сар болон дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор ТАЗ-д тус тус хүргүүлсэн байна.

Төрийн албаны эрх бүхий албан тушаалтны буруу шийдвэрээр 2015-2017 оны хооронд ажлаасаа чөлөөлөгдөж, шүүхийн шийдвэрээр ажилдаа буцан орсон 36 албан хаагч, ажилгүй байсан хугацааны цалин хөлсөд 163,817.8 мянган төгрөг, НДШ төлөлтөд 15,561.8 мянган төгрөг төлүүлж, НД-ын дэвтэрт нөхөн бичилт хийлгэн, улсын тэмдэгтийн хураамжид 920.1 мянган төгрөгийг төрөөс төлүүлсэн байна.  Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.-ийн 103.1[13], Иргэний тухай хуулийн

[13] Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ,

498.5[14] дахь заалтыг зөрчсөн тул Захиргааны ерөнхий хуулийн 103.2[15].-т заасны дагуу эрх бүхий 2 албан тушаалтны асуудлыг Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газарт, эрх бүхий 1 албан тушаалтантай холбогдох асуудлыг Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний Ерөнхий газрын Хяналт, мониторингийн газарт, эрх бүхий 23 албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг барагдуулах ажлыг зохион байгуулж, хуулийн дагуу төрийг хохиролгүй болгох хугацаатай албан албан шаардлагыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд тус тус хүргүүллээ. /хавсралт №1, Хавсралт №2, Хавсралт №3 /

### 2.3. Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын хураамжийн орлого, түүний зарцуулалтыг аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.



**УАСШ-ын төлбөрийг бэлнээр зарцуулсан байна.**

ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 7.2-т /Орон тооны бус Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг яам, агентлагийн болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын жилийн төсөвт тусгуулах замаар санхүүжүүлнэ. Үүний тулд Салбар зөвлөл нь үйл ажиллагааныхаа жилийн төсвийн саналыг боловсруулж, байгууллагын төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулна/ гэж заасан. Үүний дагуу Дундговь аймгийн ТАСЗ - нь аймгийн ЗДТГ-ын төсөвт, төсвийн саналаа тусгуулахаар өгсөн боловч үйл ажиллагааны зардал журмын дагуу огт батлагдаж байгаагүй байна. Харин Сангийн яамнаас аймгийн ЗДТГ-ын төсөвт багтаан зарцуулах талаар чиглэл өгсөн гэсэн тайлбар өглөө.

ТАСЗ-ийн ажиллах журмын 1.9-т заасны дагуу аймгийн ЗДТГ ТАСЗ -д үйл ажиллагаа явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, бичиг хэргийн хэрэгслээр хангахын хамт эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлж ажилласан байна.

2015-2017 онд 4.4 сая төгрөгийн шалгалтын хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт № 7 ТАХ-ийн шалгалт өгсөн иргэдийн судалдаа /мянган төгрөгөөр/

| Гүйлгээний утга | 2015 | | | 2016 | | | 2017 | | | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ш.too | Хүний тоо | Нийт орлого | Ш.too | Хүний тоо | Нийт орлого | Ш.too | Хүний тоо | Нийт орлого | |
| **Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт** | 2 | 152 | 912.0 | 2 | 168 | 1,008.0 | 3 | 244 | 1,464.0 | 3,384.0 |
| **Удирдах ажилтны сонгон шалгаруулалт** | 6 | 41 | 410.0 | 3 | 9 | 90.0 | 8 | 56 | 560.0 | 1,060.0 |
| **нийт** | 8 | 193 | 1,322.0 | 5 | 177 | 1,098.0 | 11 | 300 | 2,024.0 | 4,444.0 |

ТАСЗ - ийн үйл ажиллагааны зардал батлагдаагүй, харин төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтын хураамжийг өмнөх аудитаар

[14] Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй

[15] Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.

өгөгдсөн албан шаардлагын дагуу аймгийн ЗДТГ-ын дансанд төвлөрүүлэн үйл ажиллагаандаа хуулийн дагуу зарцуулсан байна.

Харин удирдах ажилтны сонгон шалгаруулалтын 2015-2017 оны шалгалтын хураамжийн орлогоос төвлөрсөн 1,060.0 мянган төгрөгийг сонгон шалгаруулалтын комиссын гишүүдэд хоолны төлбөрт бэлнээр олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 /Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана/, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 7.5-д /Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагын санхүүд гаргаж өгнө/ заасныг тус тус зөрчсөн байна.

Цаашид хууль, журмын дагуу ТАСЗ-ийн үйл ажиллагааны орлого, зардлыг ЗДТГ-ын санхүүгийн тайланд тайлагнаж хэвших нь зүйтэй байна.

## *БҮЛЭГ 3.* Төсвийн байгууллагууд хүний нөөцийн бодлого, стратеги төлөвлөгөөгүй ажиллаж байна.

### 3.1. Төрийн байгууллагууд хүний нөөцийн бодлого стратеги төлөвлөгөөгүй ажиллаж, удирдах болон төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулалтгүйгээр томилжээ.

Төсвийн байгууллагуудын хувьд хүний нөөцийн бодлого, стратеги төлөвлөгөө байхгүй бөгөөд ихэвчлэн байгууллагын жилийн төлөвлөгөөнд хүний нөөцтэй холбоотой асуудлын талаар тусгаж оруулсан байна.

Зарим байгууллагууд төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо бий болоход ТАСЗ-д захиалга өгөлгүй шууд түр орлон гүйцэтгэгчээр томилж, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүн гараагүй байхад түр орлон гүйцэтгэгчээр ажиллуулж, ТЗ болон ТҮ-ний шатлалаар цалинжуулах, төрийн албаны сул орон тоонд нэр дэвшигдсэн иргэнийг хуулийн дагуу томилоогүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн нь хүний нөөцийн бодлого хангалттай хэмжээнд хэрэгжихгүй байгааг илтгэж байна.

Дээрх нийтлэг зөрчлүүдийг байгууллага бүрээр харуулбал:

*Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд:*

Төрийн албанд анх ороход авах мэргэшлийн шалгалт өгөөгүй боловч томилогдон ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгааг харуулж байгаа бөгөөд дараах шалтгаантай байна. Хүснэгт № 8

*Үүнд:*

- *Цагаандэлгэр сумын Мал эмнэлэг үржлийн тасгийн жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Ж.Ундрахбаяр /тусгай дунд боловсрол/,* Боловсрол, соёл,

*урлагийн газрын мэргэжилтэн Г.Бат-Эрдэнэ /дээд боловсролтой/ нар тухай ажлын байранд тавигдах боловсролын түвшинг хангаагүй байхад авч ажиллуулсан.*

- *ИГЧБЦГХЗ –ны байгаль хамгаалагч Х.Эрдэнэбат, Сайхан-Овоо сумын Мал эмнэлэг үржлийн тасгийн малын үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн Р.Оюунтуяа нарын мэргэжил тухай ажлын байранд тавигдах мэргэжлээс зөрүүтэй байхад авч ажиллуулсан.*
- *Аймгийн ХХҮГазрын Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Ц.Ууганнасандорж, Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэбаатар, Өндөршил сумын Төрийн сангийн мэргэжилтэн Т.Отгондулам, Нийгмийн бодлогын мэргэжилтэн Б.Нарандэлгэр нарын ажлын байрны захиалга өгөлгүй, сонгон шалгаруулалт явуулалгүйгээр авч ажиллуулсан.*
- *Бусад албан тушаалтны хувьд ажлын байрны захиалга өгсөн болови шалгалтад тэнцээгүй, 2018 онд шинээр томилогдсон албан тушаалтнуудыг томилсон байна.*

Хүснэгт № 8 ТАХ-ийн шалгалт өгөөгүй иргэдийн судалгаа

| № | Байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Ажилд томилсон Огноо | Цалингийн шатлал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Боловсрол, соёл, урлагийн газар | Дүрслэх урлаг, технологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн | Г.Бат-Эрдэнэ | 2017.05.01 Б/15 | ТҮБД-5-5 |
| 2 | ХХҮГазар | Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | Ц.Ууганнасандорж | 2017.11.20 Б/48 | ТҮ-6-1 |
| 3 | Сайхан-Овоо ЗДТГ | Хөдөлмөр, Халамжийн асуудал хариуцсан | Д.Дашпагма | 2018.03.14 Б/11 | ТҮ-6-1 |
| 4 | ИГЧБЦГХЗ | Байгаль хамгаалагч | Х.Эрдэнэбат | 2014.12.22 Б/42 | ТҮ-2 |
| 5 | НДХ | ЭМД-ын орлогын байцаагч | Г.Осоржамаа | 2018.03.16 Б/08 | ТҮ-5-1 |
| 6 | НДХ | Цагаандэлгэр сумын байцаагч | Х.Оюун-Амгалан | 2018.04.04 Б/14 | ТҮ-5-4 |
| 7 | НДХ | Хулд сумын байцаагч | Б.Номуундарь | 2018.03.16 Б/09 | ТҮ-5-1 |
| 8 | Өндөршил ЗДТГ | Төрийн сангийн мэргэжилтэн | Т.Отгондулам | 2016.10.24 Б/15 | ТҮ- 8-4 |
| 9 | Өндөршил ЗДТГ | Нийгмийн бодлогын мэргэжилтэн | Б.Нарандэлгэр | 2018.05.01 Б/05 | ТҮ-6-1 |
| 10 | Өндөршил ЗДТГ | Малын бүртгэл эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн | О.Ганбаатар | 2018.04.02 Б/02 | ТҮ-6-1 |
| 11 | Говь-Угтаал ЗДТГ | Газрын даамал | Т.Шуухааз | 2018.03.19 Б/10 | ТЗ-3 |
| 12 | Сайхан-Овоо ЗДТГ | Мал эмнэлэг үржлийн тасаг Малын үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн | Р.Оюунтуяа | 2017.07.19 Б/15 | ТҮ-4-1 |
| 13 | Цагаандэлгэр ЗДТГ | МЭҮ тасаг ЖДҮХ мэргэжилтэн | Ц.Ундахбаяр | 2017.02.03 Б/03 | ТҮ-5-5 |

Мөн тухайн байгууллагад гарсан сул орон тоо буюу ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж шалгалтад тэнцэж, онооны дараалллаар бусад хүмүүсээс өндөр оноо авсан эсвэл өмнө нь нөөцөд бүртгэлтэй, нөөцөөс нэр дэвшүүлсэн хүнийг тухайн албан тушаалд томилохоос татгалзах явдал зарим байгууллагад гарч байна.



**ТАХ-ийн шалгалт өгөөгүй иргэд шууд томилогдож байна.**

Энэ нь зарим албан тушаалтнууд улс төржин, хувийн ашиг сонирхол гаргаж өөрийн нам, найз нөхөд, төрөл садангийн хүнийг авч ажиллуулах санаархалтай холбоотой бөгөөд тухайн ажлын байр нөхөгдөхгүй удаж, төрийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж зарчим алдагдаж байна. Тухайлбал

Дундговь аймаг дахь Шүүхийн Тамгын газар, ГХБХБГ, Өндөршил, Дэлгэрцогт сумын ЗДТГ-аас зарласан сул орон тоонд төрийн албаны нөөцөд бүртгэлтэй хүмүүсийг салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн боловч холбогдох албан тушаалтнууд ажлын туршлага бага, өөр хүн ажиллуулах болсон, өмнө нь эрхэлж байсан ажилдаа хариуцлагагүй хандсан зэрэг шалтгаанаар авч ажиллуулаагүй байна.

Хүснэгт № 9 ТАСЗ-өөс нэр дэвшүүлсэн ч томилогдоогүй иргэдийн судалгаа

| № | Зарлагдсан ажлын байр | | | | | | Томилогдсон хүний овог нэр | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Захиалга өгсөн газар байгууллагын нэр | Нэгжийн нэр | Ажлын байрны | | | | | |
| | | | нэр | хариуцсан асуудал | ангилал-зэрэглэл | орон тоо | | |
| 1 | Дундговь аймаг дахь Шүүхийн Тамгын газар | Дундговь аймаг дахь Сум дундын эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүх | Шүүгчийн туслах | Шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд туслах, шүүх хуралдааны бэлтгэл хангах, хэргийн оролцогчдод мэдээлэл өгөх, захирамжлалын баримт бичгийн төсөл боловсруулах | ТЗ-6 | 1 | Мягмарханд | Төрийн албаны 2016 оны 10 сарын мэргэшлийн шалгалтаар |
| 2 | ГХБХБГ | БХБ-ын хэлтэс | Мэргэжилтэн | Барилга угсралт, техникийн хяналт хариуцсан | ТЗ-5 | 1 | Батхуяг Отгонмаа | Байгууллага томилохоос татгалзсан |
| 3 | Өндөршил | ЗДТГ | Мэргэжилтэн | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил, хүнсний аюулгүй байдал хариуцсан | ТЗ-3 | 1 | Б.Батмөнх | Байгууллага томилохоос татгалзсан |
| 4 | Дэлгэрцогт | ЗДТГ | Мэргэжилтэн | Төрийн сангийн асуудал | ТЗ-3 | 1 | Б.Баатарсүрэн | Байгууллага татгалзсан |

Дээрхи зөрчлүүд нь Төрийн албаны тухай хуулийн 17.1-т /Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө/, 17.4-т /Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина/, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар

тогтоолын 4.3.3-т /байгууллагын даргаас бусад удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар тус тус орлон гүйцэтгүүлнэ/, журмын 5.4-т /Эзгүй байгаа албан хаагчийн болон сул орон тоо гарсан албан тушаалын албан үүргийг энэ журамд зааснаас бусад этгээдээр түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно/, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1-т /Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4-т заасны дагуу нөхөх боломжгүй тохиолдолд иргэнийг сонгон шалгаруулж авах захиалгыг байгууллага нь ажлын байр тус бүрээр гарган, Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-д нийцүүлэн боловсруулсан Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтын хамт энэхүү журмын 1.4-т заасан харъяаллын дагуу Төрийн албаны зөвлөл болон аймаг, нийслэл дэх Салбар зөвлөлд хүргүүлнэ/ гэж заасныг тус тус зөрчсөн байна. Иймд зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

*Удирдах албан тушаалтны хувьд:*

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтад шалгалт өгөөгүй боловч томилогдон ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгааг харуулж байгаа бөгөөд дараах шалтгаантай байна. Хүснэгт № 10

*Үүнд :*

- *Аймгийн ИТХ -ын төлөөлөгч Г.Бат-Оршихыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр, Эрдэнэдалай сумын ИТХ-ын төлөөлөгч Д.Эрдэнэбаатарыг Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын даргыг түр орлон гүйцэтгэгчээр удирдах ажилтны сонгон шалгаруулалтгүйгээр томилсон.*
- *Нэгдсэн эмнэлгийн дарга Х.Жаргал сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон бөгөөд эмнэлгийн тусламжийн тухай хуульд зааснаар удирдах зөвлөлийг байгуулан даргыг сонгох ёстой болович Эрүүл мэндийн яамнаас уг журмыг батлаагүй байна.*
- *Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Г.Батжаргал, Татварын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч М.Туяацэцэг, Дэлгэрцогт Хүн Эмнэлгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Д.Лувсандагва, Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны ерөнхий нягтлан бодогч А.Соёл-Эрдэнэ нарыг сонгон шалгаруулалтгүйгээр шууд томилсон байна.*

Хүснэгт №10 ТАХ-ийн шалгалт өгөөгүй удирдах албан тушаалтан

| № | Сум, байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Томилсон тушаалын огноо, дугаар | Цалингийн шатлал | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийн газар | Даргын үүрэг гүйцэтгэгч | Гантөмөр Бат-Орших | 2017.11.01 Б/43 | ТЗ-9-4 | Шалгалт өгөөгүй. 2018 онд захиалга өгсөн |
| 2 | Нэгдсэн эмнэлэг | Ерөнхий эмч | Хүдэрчөдөр Жаргал | 2012.04.04 Б/12 | ТҮЭМ-8-4 | 6 сард шийдвэр гарна |
| 3 | Дэлгэрцогт Хүн Эмнэлэг | Үүрэг гүйцэтгэгч | Д.Лувсандагва | 11/7/2016 | ТҮЭМ-6-1 | Шалгалт өгөөгүй |
| 4 | НДХ | Хэлтсийн дарга | Г.Батжаргал | 2018.03.28 №Б/54 | ТҮ-11-5 | Шалгалт өгөөгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Эрдэнэдалай ЗДТГ | ЗДТГ-ын дарга түр олон гүйцэтгэгч | Д.Эрдэнэбаатар | 2018.01.18 Б/01 | ТЗ-7-2 | Шалгалт өгөөгүй ажлын байрны захиалга өгөөгүй |
| 6 | Эрдэнэдалай ЗДТГ | ЗДТГ-ын Санхүүгийн албаны ерөнхий ня-бо | А.Соёл-Эрдэнэ | 2018.04.18 Б/13 | ТҮ-8-3 | Шалгалт өгөөгүй |
| 7 | Татварын хэлтэс | Даргын үүрэг гүйцэтгэгч | М.Туяацэцэг | 2016.12.27. | ТЗ-9-4 | Шалгалт өгөөгүй |

Цагаандэлгэр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Эрдэнэдалай сумын ИТХ-ын нарийн бичгийн даргад ТАСЗ-өөс нэр дэвшүүлсэн иргэдийг томилоогүй байна.

- *Цагаандэлгэр сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд 2015 оны 01 сарын 27-ны өдрийн удирдах ажилтны сонгон шалгаруулалтаар 2 хүн өрсөлдөж, Б.Батцэнгэл, 04 сарын 10-ны өдрийн сонгон шалгаруулалтаар 9 хүн өрсөлдөж Ш.Шижирбат шалгарч ТАСЗ-өөс дээрх хүмүүсийг нэр дэвшүүлсэн боловч эрх бүхий албан тушаалтнууд томилоогүй байна. Харин 2017 оны 06 сарын 15-ны өдрийн сонгон шалгаруулалтаар 5 хүн өрсөлдөж, Ч.Бямбасүрэн шалгарч ТАСЗ-ийн санал болгосноор ИТХ-ын нарийн бичгийн даргаар томилсон байна.*
- *Эрдэнэдалай сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд 2017 оны 06 сарын 15-ны өдрийн сонгон шалгаруулалтаар 2 хүн өрсөлдөж, Л.Уранбилэг шалгарч, ТАСЗ-өөс нэр дэвшүүлсэн боловч Эрдэнэдалай сумын ИТХ-аас Л.Уранбилэгийг ашиг сонирхлын зөрчилтэй гэж татгалзсан байна. Уг асуудал одоогоор шүүхийн шатад явагдаж байна.*

Дээрх зөрчлүүдтэй холбоотой гаргасан шийдвэр нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг /хууль тогтоомжид заасан бол нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллагын удирдлагыг аймаг, нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх/-ыг үндэслэсэн нь хууль эрх зүйн орчин хангаагүй байна. Учир нь уг заалтад “...Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн...” гэж заасныг зөрчсөн байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн Төрийн албаны тухай хуулийн 15.1 /Төрийн жинхэнэ албан хаагч дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:/, 15.1.8. /аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;/ 17.1-т/, 17.4-Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.2, 4.3.3-т, 5.4-т Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1-т заасныг тус тус зөрчсөн байна. Эдгээр зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

### 3.2. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний 2017 оны нэгдсэн дүн гараагүй байна.

Дундговь аймагт төрийн болон орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд төдийгүй шүүхийн байгууллагуудыг оролцуулан нийт 135 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн албанд 2017 оны байдлаар 135 байгууллагад 3210 төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс 365 буюу 11.37% нь төрийн захиргааны албан хаагч, 106 буюу 3.3% нь улс төрийн албан хаагч, 116 буюу 3.6% нь төрийн тусгай, 2623 буюу 81.71% нь төрийн үйлчилгээний албан хаагч ажиллаж байна.

График № 2




Төрийн албан хаагчийн тоо 2016 онд 3241, 2017 онд 3210 болж буусан байна.

Төрийн албан хаагчийн тооны бууралт нь яам, агентлагуудыг нэгтгэж өөрчлөн байгуулснаар тус аймагт Хөдөлмөрийн хэлтсийг Нийгмийн халамжийн хэлтэстэй, Худалдан авах ажиллагааны албыг Орон нутгийн өмчийн албатай нэгтгэн зохион байгуулсантай холбоотой байна.

2016 оны Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн мэдээллийг төсвийн байгууллагууд ХАМР программд оруулсан бөгөөд программыг байгууллага бүрт зөөж суурилуулах явцад эвдрэл гарах, шинэ орсон ажилтанд заавал сургалт шаардагддаг, зарим үзүүлэлтүүдийг программд оруулах боломжгүй байсан байна. Тухайлбал зэрэг дэвтэй холбоотой мэдээллийг программд оруулах боломжгүй байсан. Харин 2017 оны мэдээллийг Төрийн албаны цахим хуудсанд байрших шинэчлэн боловсруулсан хүний нөөцийн улсын нэгдсэн бүртгэлийн системээр авсан байна.

Гэвч тус программын боловсруулалт бүрэн дуусаагүй, программын шинэчлэл хийгдэж байгаагаас аймгийн төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний нэгтгэсэн тайлан гараагүй байна.

График № 3




| | Улс төр | Төрийн тусгай | Төрийн захиргаа | төрийн үйлчилгээ |
|---|---|---|---|---|
| 2017 он | 106 | 116 | 365 | 2623 |
| 2016 он | 111 | 104 | 379 | 2647 |

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт өгч байна. Үүнд:

1. Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдаж байна.
2. ТАЗ нь ТАСЗ -ийг арга зүйн удирдлагаар хангаж байгаа боловч орон нутгийн ТАСЗ -ийн хараат бус байдал бүрэн хангагдахгүй байна.
3. Төрийн албаны Дундговь дахь салбар зөвлөл 2017 онд тавьсан зорилтоо 96.4 хувьтай биелүүлсэн байна.
4. Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт зөвхөн төрийн байгууллагуудаас ирүүлсэн захиалгаар хязгаарлагдаж байна.
5. Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа, шалгалттай холбоотой өргөдөл, гомдлыг журмын дагуу бүрэн шийдвэрлэсэн байна.
6. Төрийн албаны Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын хураамжийн орлого, түүний зарцуулалтыг аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.
7. Төрийн байгууллагууд хүний нөөцийн бодлого стратеги төлөвлөгөөгүй ажиллаж, удирдах болон төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулалтгүйгээр томилжээ.
8. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний 2017 оны нэгдсэн дүн гараагүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

**Төрийн албаны зөвлөлийн Дундговь дахь салбар зөвлөлд:**

1. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалыг орон тооны болгож бие даасан байдлаар ажиллуулах, төрийн албаны салбар зөвлөлийн хууль тогтоомжоор олгогдсон хараат бус бие даасан байдлыг хангаж, төрийн албаны шинэтгэлийн бодлогыг орон нутагт бүрэн хэрэгжүүлэх нөхцөл боломж, эрх мэдлийг нь нэмэгдүүлж үүрэг хариуцлагыг сайжруулах талаар ТАЗ-д санал хүргүүлэх.
2. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой одоо мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хүчингүй болсон буюу Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн заалтыг үндэслэсэн заалтууд байсаар байгаа тул өөрчлөлт оруулах талаар ТАЗ-д санал хүргүүлэх.
3. 2016 онд хэрэгжиж дууссан хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн, дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгцээ шаардлагатай байгаа хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлон, хэрэгжүүлж ажиллах.
4. Төсвийн байгууллагуудын батлагдсан орон тооны судалгааг авч, төрийн албаны шалгалт өгөөгүй албан хаагчид болон захиалга өгөөд албан хаагч томилогдоогүй ажлын байранд хяналт тавьж, сонгон шалгаруулалт зарлах бүрдээ нөхөгдөөгүй ажлын байруудад шалгаруулалт зохион байгуулж ажиллах.
5. Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын хураамжийн орлого, түүний зарцуулалтыг аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайланд тайлагнаж хэвших.
6. Аймгийн хэмжээнд хүний нөөцийн бодлого, стратеги төлөвлөгөө боловсруулан, хяналт тавьж хэрэгжилтийг тооцож ажиллах.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР Д.ИХБАЯР

АУДИТОР Д.ДОЛЖИНСҮРЭН

ХЯНАСАН : АУДИТЫН МЕНЕЖЕР Х.НАРАНЦАЦРАЛ

## ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг Төрийн албаны салбар зөвлөлд танилцуулж санал тайлбарыг авлаа.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

48090 Мандалговь, Дундговь аймаг,
Утас: 7059-2494, Факс: 7059-2896,

2018.06.06 № 67

танай ____________ -ны № ____________ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дундговь аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгагдсан асуудалтай холбоотой санал тайлбар байхгүй байна.

Тайланд тусгагдсан зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН

## ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 05 өдөр Дугаар А/12 Мандалговь

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4, Нийцлийн аудитын түр журмын 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа"-нд хийсэн нийцлийн аудитын тайлан /ДУА-2018-01-НА/-г батласугай.

2. "Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа"-нд хийсэн нийцлийн аудитын тайланг Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөл болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Нийцлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2018 оны 12 дугаар сарын 10-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн дарга Ц.Эрдэнэсүрэнд зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, Нийцлийн аудитын албаны ахлах аудитор /Д.Ихбаяр/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА

Äóí äãî âü àéì аãдахь Төрийн ауäèòûí ãàçðûí
тэргүүлэх àóäèòîð ûí 2018 îíû 06 äугаар ñàðûí
05 - ны өдрийн А/12 дугаар òóø ààëûí 1 ä¿ãýýð õàâñðàëò

## АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

**Аудитын код:** ДУА-2018-01-НА
**Аудитын нэр:** “Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа”

| № | Зөрчлийн товч утга | Зөрчигдсөн хуулийн заалт | Зөрчлийн дүн сая.төг | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Аудитын явцад барагдуулсан | Акт тавигдсан | Албан шаардлага өгсөн | Тоо |
| 1 | Төрийн албаны эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр 2015-2017 оны хооронд ажлаасаа чөлөөлөгдөж, шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа орсон 29 албан хаагч, ажилгүй байсан хугацааны цалин хөлсөнд 148,812.8 мянган төгрөг, НДШ төлөлтөд 14,361.4 мянган төгрөг төлүүлж, НДШ-ийн дэвтэрт нөхөн бичилт хийлгэн, улсын тэмдэгтийн хураамжид 847.0 мянган төгрөг нийт 164,021.2 мянган төгрөгийг нэхэмжлэн, төрөөс төлсөнг эрх бүхий 23 албан тушаалтнаас эргүүлэн нэхэмжилж, санхүүгийн тайланд авлагаар тусгаж, барагдуулаагүй /**Санхүүгийн хяналт, аудитын алба** / | Захиргааны ерөнхий хуулийн 103-ийн 103.1. /Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ/, Иргэний тухай хуулийн 498.5 /Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй/, Захиргааны ерөнхий хуулийн 103.2.-т /Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг | 164.02 | | | 164.02 | 1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна/ | | | | | |
| 2 | Төрийн албаны эрх бүхий албан тушаалтны буруутай ажилдаа орсон 2 албан хаагч, ажилгүй байсан хугацааны цалин хөлсөнд 5,989.45 мянган төгрөг, НДШ төлөлтөд 479.16 мянган төгрөг төлүүлж, НДШ-ийн дэвтэрт нөхөн бичилт хийлгэн, улсын тэмдэгтийн хураамжид 73.00 мянган төгрөг нийт 6,541.61 мянган төгрөгийг нэхэмжлэн, төрөөс төлсөнг эрх бүхий албан тушаалтнаас эргүүлэн нэхэмжилж, санхүүгийн тайланд авлагаар тусгаж, барагдуулаагүй. /**ЭМЯ-ны ХМГ**/ | Захиргааны ерөнхий хуулийн 103-ийн 103.1., Иргэний тухай хуулийн 498.5 /, Захиргааны ерөнхий хуулийн 103.2.-т | 6.54 | | | 6.54 | 1 |
| 3 | Төрийн албаны эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр 2015-2017 оны хооронд ажлаасаа чөлөөлөгдөж, шүүхийн шийдвэрээр 3 албан хаагчийн, ажилгүй байсан хугацааны цалин хөлсөд 9,015.61 мянган төгрөг, НДШ төлөлтөд 721.25 мянган төгрөг төлүүлж, НДШ-ийн дэвтэрт нөхөн бичилт хийлгэн, нийт 9,736.86 мянган төгрөгийг нэхэмжлэн, төрөөс төлсөнг эрх бүхий албан тушаалтнаас эргүүлэн нэхэмжилж, санхүүгийн тайланд авлагаар тусгаж, барагдуулаагүй. **/ХХҮЕГ-ын ХШҮДАГ/** | Захиргааны ерөнхий хуулийн 103-ийн 103.1., Иргэний тухай хуулийн 498.5 /, Захиргааны ерөнхий хуулийн 103.2.-т | 9.7 | | | 9.7 | 1 |
| 4 | Төрийн 59 албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгох тогтоол гаргаж, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг зөрчин, төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлсэн. **/ТАСЗ/** | УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 29 дүгээр тогтоолын 4-т, 5-д | 0 | | | | 1 |
| 5 | Төрийн албаны мэргэжлийн шалгалт өгөөгүй иргэдийг төрийн албанд хууль бусаар томилсон, сул орон тооны захиалга өгөөгүй эрх бүхий албан тушаалтангууд, мөн төрийн албаны жинхэнэ албан тушаалын шалгалтанд хамгийн өндөр оноо авсан иргэдийг томилоогүй эрх бүхий албан тушаалтнуудад хууль, журманд заасан арга хэмжээ авч ажиллаагүй. **/ТАСЗ/** | Төрийн албаны тухай хуулийн 17.3., Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай тогтоолын 2.1., Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 сарын 24-ний өдрийн 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.9. –дэх заалт | 0 | | | | 1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Аймаг сумын 10 байгууллагын удирдах албан тушаалтаныг хууль, журам зөрчин, сонгон шалгаруулалтгүй, төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтгүй, хууль бусаар томилсон. **/Аймгийн Засаг дарга/** | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 4.3.1, 4.3.2. 5.4, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам” –ын 14/а, 14/б -заалт | | | | | 1 |
| 7 | Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын дарга Э.Чагнаадорж байгууллагадаа шинээр бий болсон Говь-Угтаал сумын газрын даамлын сул орон тоонд сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалт өгөөгүй хүнийг хууль бусаар томилсон **/ГХБХБГ /** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1.-дэх заалт | 0 | | | | 1 |
| 8 | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга байгууллагадаа гарсан төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалтад өгөөгүй хүнийг хууль бусаар томилсон **/ЭМНДХ /** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1. дэх заалт | 0 | | | | 1 |
| 9 | Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Ц.Бумангэрэл байгууллагадаа гарсан дүрслэх урлаг, технологийн боловсрол хариуцсан мэргэжилтний сул орон тоонд төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгөлгүй, сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалтад тэнцээгүй хүнийг хууль бусаар томилсон. **/БСУГ/** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1.-дэх заалт | 0 | | | | 1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Р.Баттүвшин байгууллагадаа гарсан төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгөлгүй, сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалтад тэнцээгүй хүнийг хууль бусаар томилсон **/ИГЧБЦГХЗ/** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1.-дэх заалт | 0 | | | | 1 |
| 11 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Г.Хишигдаваа байгууллагынхаа төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгөлгүй, сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалтад тэнцээгүй хүнийг хууль бусаар томилсон. **/ХХҮГ/** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1.-дэх заалт | 0 | | | | 1 |
| 12 | Сумын Засаг даргын Тамгын газрын дарга З.Солонго байгууллагадаа гарсан жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний сул орон тоонд сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалт өгөөгүй, мэргэжлийн бус хүнийг хууль бусаар томилсон **/Цагаандэлгэр сумын ЗДТГ /** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1.-дэх заалт | 0 | | | | 1 |
| 13 | Эрдэнэдалай сумын Засаг дарга С.Мөнхбаатар сумын Засаг даргын Тамгын газарт гарсан төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгөлгүй, сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалт өгөөгүй хүнийг хууль бусаар томилсон. **/Эрдэнэдалай сумын ЗДТГ/** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 4.3.2, 4.3.3, 5.4, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам” –ын 14/а, 14/б, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1-дэх заалт | 0 | | | | 1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Болоржаргал байгууллагадаа гарсан малын үржлийн бүртгэл хариуцсан мэргэжилтний сул орон тоонд сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалт өгөөгүй, мэргэжлийн бус хүнийг хууль бусаар томилсон. **/Сайхан-Овоо сумын ЗДТГ/** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1.-дэх заалт | 0.0 | | | | 1 |
| 15 | Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Амгаланжаргал байгууллагадаа гарсан төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгөлгүй, сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалт өгөөгүй хүнийг хууль бусаар томилсон. **/Өндөршил сумын ЗДТГ/** | Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4, Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4.3.3, 5.4, Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журмын, заавар батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолын 2.1.-дэх заалт | 0.0 | | | | 1 |
| | **Дүн** | | **180.3** | **0.0** | **-** | **180.3** | **16** |

## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

### Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас барагдуулах зөрчлийн жагсаалт

| № | Шийдвэр гаргагч эрх бүхий албан тушаалтан | | | | Нэхэмжлэгч | | Шүүхийн шийдвэрийн огноо | Эрх бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирол | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Байгууллагын нэр** | **Ажлаас халсан тушаал огноо** | **Албан тушаал** | **Овог нэр** | **Албан тушаал** | **Овог нэр** | | **Шүүхийн шийдвэр** | **НДШ зардал** | **ТХ** | **Нийт** |
| **1** | Аймгийн ЗДТГ | 2014.06.02 №75 | Ерөнхий сайд | Н.Алтанхуяг | Аймгийн засаг дарга | С.Сүхбаатар | 2017.01.07 №139/055 | 36,767.3 | 7,053.8 | 30.0 | 43,851.0 |
| **2** | | 2016.11.24 Б/60 | ЗДТГ-ын дарга | О.Чулуунбат | ХОХБТХ дарга | Х.Отгонжаргал | 2017.03.13 №117/009 | 814.1 | 255.8 | - | 1,069.9 |
| | | 2016.11.22 Б/54 | | | Мэргэжилтэн | Ж.Түмэндэлгэр | 2017.05.08 №14 | 5,087.5 | 407 | 95.2 | 5,589.7 |
| **3** | Өмчийн алба | 2016.12.01 Б/07 | Дарга | С.Ууганбаяр | Мэргэжилтэн | Э.Мядагмаа | 2017.02.16 №139/00072 2017.09.04 №139/00319 | 2,795.8 | 223.7 | - | 3,019.5 |
| **4** | Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс | 2017.01.02 Б/05 | Дарга | Ц.Ганзориг | Хүүхдийн зуслангийн зохион байгуулагч | Д.Энхтамир | 2017.03.21 №139/00105 | - | 110.1 | | 110.1 |
| **5** | Номын сан | | Дарга | А.Нансалмаа | Номын санч | Ц.Оюунжаргал | 2015.02.06 №35 | 3,267.6 | 261.4 | - | 3,529.0 |
| **6** | | | | Д.Мөнхзул | Номын санч | Ц.Мөнхзаяа | 2015.11.23 №358 | 1,166.8 | 93.3 | 45.4 | 1,305.6 |
| | | | | | Номын санч | Ц.Мөнхзаяа | 2016.12.06 №263 | 6,128.3 | 490.3 | - | 6,618.5 |
| | | | | | Номын санч | Ц.Оюунжаргал | 2016.01.25 №20 | 659.5 | 52.8 | - | 712.3 |
| | | | | | Номын санч | Ц.Оюунжаргал | 2017.09.05 №229 | 4,346.9 | 347.7 | - | 4,694.6 |
| **7** | | | | Ц.Одончимэг | Нягтлан бодогч | А.Эрдэнэмөнх | 2017.01.10 №139/007 | 1,361.5 | 108.9 | - | 1,470.4 |
| | | | | | Жолооч | Х.Дэлгэрсуурь | 2017.02.01 №139/00145 | 1,518.7 | 121.5 | 25 | 1,665.4 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Сц-1-р цэцэрлэг | 2017.05.12 Б/12 | Эрхлэгч | М.Борхүүхэн | Нярав | Ц.Наранчимэг | 2017.07.31 | 3,893.0 | 350.4 | 30 | 4,273.4 |
| 9 | СЦ-2-р цэцэрлэг | 2017.08.30 Б/15 | Эрхлэгч | Ж.Туул | Жижүүр | Д.Отгонбаяр | 2017.11.23 №139/00419 | 956.6 | 76.53 | - | 1,033.1 |
| 10 | Аймгийн ЗДТГ | 2016.04.22 Б/11 | Аймгийн засаг дарга | С.Од-Эрдэнэ | ХОХБТХ-ийн дарга | Ж.Нармандах | 2016.08.04 №10 | 2,364.0 | 189.1 | 70.2 | 2,623.3 |
| | СЦ-5-р цэцэрлэг | 2015.11.06 Б/448 | | | Эрхлэгч | Л.Дэлгэрмаа | 2016.03.01 №139/00060 | 3,101.2 | 248.1 | - | 3,349.3 |
| | Адаацаг Сургууль | 2015.10.07 Б/408 | | | Сургуулийн захирал | Ж.Энхтуул | 2016.03.03 №139/00064 | 2,517.4 | 201.4 | 125.4 | 2,844.2 |
| | Адаацаг Сургууль | 2015.10.07 Б/408 | | | Сургуулийн захирал | Ж.Энхтуул | 2016.11.04 139/00307 | 4,235.6 | 338.8 | 82.7 | 4,657.2 |
| 11 | Адаацаг Сургууль | 2014.03.06 | Сургуулийн захирал | Ю.Нэмэхбаяр | Нийгмийн ажилтан | С.Батхуяг | 2016.04.05 №139/00094 | 4,707.3 | 376.6 | 90.3 | 5,174.1 |
| 12 | Баянжаргалан Эмнэлэг | 2016.12.09 Б/34 | Дарга | Д.Доржмаа | Жолооч | А.Пүрэвдорж | 2017.04.03 №139/00122 | 1,793.7 | 143.0 | - | 1,936.7 |
| 13 | Баянжаргалан ЗДТГ | 2016.11.16 А/51 | Засаг дарга | Г.Туяа | Засаг даргын орлогч | Х.Болдбаатар | 2017.03.10 №08 2017.11.17 №139/00404 | 6,268.8 | 422.5 | 36.3 | 6,727.7 |
| 14 | Говийн ирээдүй цогцолбор сургууль | 2015.08.24 Б/25 | Сургуулийн захирал | Г.Мягмарсүрэн | Багш | П.Туяа | 2016.01.15 | - | - | - | - |
| | | 2015.08.17 Б/23 | | | Сургалтын менежер | Л.Галиндмаа | 2016.10.27 | 11,223.2 | 897.7 | - | 12,121.1 |
| 15 | Говь-угтаал ИТХ | 2015.01.11 | Сумын ИТХ-ын дарга | Д.Дулам | ИТХ-ын нарийн бичгийн дарга | В.Нямсүрэн | 2016.01.16 №09 | 9,776.5 | - | 70.2 | 9,846.7 |
| 16 | Говь-угтаал ЗДТГ | 2015.12.21 | Сумын засаг дарга | Т.Энхцэцэг | ЗДТГ-ын дарга | Г.Эрдэнэцэцэг | 2016.09.06 №13 | 14,489.6 | - | - | 14,489.6 |
| 17 | Гурвансайхан ЗДТГ | 2015.09.02 Б/19 | ЗДТГ-ын дарга | Р.Мөнхбаясгалан | Санхүү албаны дарга | Ү.Алимаа | 2015.11.24 №09 | 754.0 | 60.3 | - | 814.3 |
| 18 | Гурвансайхан ЗД | 2015.01.05 Б/01 | Сумын засаг дарга | Д.Төмөртогтох | ЗДТГ-ын дарга | Б.Энхтуяа | 2015.12.07 №349 | 8,669.6 | 693.6 | - | 9,363.2 |
| 19 | Сайхан-овоо цэцэрлэг | | Цэцэрлгийн эрхлэгч | Д.Сарнай | Багш | Б.Гансүх | 2016.01.26 №35/16-02 | 4,727.1 | 378.2 | - | 5,105.3 |
| 20 | Сайхан-овоо сургууль | 2017.10.04 Б/35 | Дарга | О.Түмэнбаатар | Нярав | Ц.Дэлгэрмаа | 2018.01.12 №139/00025 | 1,264.6 | 113.8 | 105.1 | 1,483.5 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **21** | Дэлгэрхангай цэцэрлэг | 2016.05.31 Б/08 | Цэцэрлгийн эрхлэгч | Д.Будням | Туслах багш | Ө.Амаржаргал | 2016.10.21 №139/00295 | 1,508.9 | 120.7 | 41.2 | 1,670.8 |
| **22** | Луус соёлын төв | 2015.05.27 Б/04 | СТ эрхлэгч | Э.Отгончимэг | Номын санч | Б.Эрдэнчимэг | 2015.08.13 №244 | 1,101.6 | 88.1 | - | 1,189.8 |
| **23** | Луус ЗДТГ | 2015.04.30 Б/10. 2016.07.27 Б/09 | ЗДТГ-ын дарга | Б.Энхжаргал | Мэргэжилтэн | Б.Алтанчимэг | 2016.11.02 №139 | 1,545.6 | 136.01 | - | 1,681.6 |
| | | | | | | | - | 148,812.7 | 14,361.4 | 847.1 | 164,021.2 |

## Хөдөлмөр, халамж, үйлчилгээний Ерөнхий газрын Хяналт, мониторингийн газрын барагдуулах зөрчлийн жагсаалт

Хавсралт №2

| № | Шийдвэр гаргагч эрх бүхий албан тушаалтан | | | | Нэхэмжлэгч | | Шүүхийн шийдвэрийн огноо | Эрх бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирол | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Байгууллагын нэр** | **Ажлаас халсан тушаал огноо** | **Албан тушаал** | **Овог нэр** | **Албан тушаал** | **Овог нэр** | | **Шүүхийн шийдвэр** | **НДШ зардал** | **ТХ** | **Нийт** |
| 1 | Хөдөлмөр, Халамж, Үйлчилгээний Газар | 2016.09.30 Б/13 | Дарга | Г.Хишигдаваа | Мэргэжилтэн | С.Бямбамаа | 2017.01.17 №117/004 | - | - | - | - |
| | | 2016.10.03 Б/18 | | | Мэргэжилтэн | Ө.Түмэнжаргал | 2017.02.06.№4 | - | - | - | - |
| | | 2016.10.03 Б/15 | | | Мэргэжилтэн | Д.Цэвэлмаа | 2017.02.07 №5 | 764.9 | 61.1 | - | 826.1 |
| | | 2016.10.03 Б/16 | | | Мэргэжилтэн | Л.Өлзий-Отгон | 2017.03.23 №11 | 3,066.3 | 245.3 | - | 3,311.6 |
| | | 2016.10.03 Б/17 | | | Мэргэжилтэн | Б.Дашбилэг | 2017.07.24 №17 | 5,184.3 | 414.7 | - | 5,599.0 |
| | | | | | | | | **9,015.6** | **721.2** | **-** | **9,736.9** |

Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар барагдуулах зөрчлийн жагсаалт

Хавсралт №3

| № | Шийдвэр гаргагч эрх бүхий албан тушаалтан | | | | Нэхэмжлэгч | | Шүүхийн шийдвэрийн огноо | Эрх бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирол | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллагын нэр | Ажлаас халсан тушаал огноо | Албан тушаал | Овог нэр | Албан тушаал | Овог нэр | | Шүүхийн шийдвэр | НДШ зардал | ТХ | Нийт |
| **1** | Эрүүл мэндийн газар | | Газрын дарга | Ц.Энхсайхан | УАУТ дарга | Л.Бямбаа | 2015.11.16 | 2,361.6 | 188.9 | - | 2,550.5 |
| **2** | Нэгдсэн эмнэлэг | | Дарга | Х.Жаргал | | Б.Өлзийсайхан | 2016.10.21 | 3,627.8 | 290.2 | 73.0 | 3,991.0 |
| | | | | | | | | **5,989.45** | **479.16** | **73.00** | **6,541.60** |